

“ОРХОН ХӨГЖИЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04-р сарын 28-ны өдрийн 11.00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, UB MART худалдааны төвийн 519 тоотод “Орхон хөгжил” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхлэв.

Энэхүү ээлжит хурлыг зохион байгуулах комиссын гишүүд хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийг холбогдох журмын дагуу бүртгэн авч ирцийг тооллогын комисст хүлээлгэн өгөв.

Хуралд компанийн нийт 117'437 ширхэг хувьцааны 101'210 ширхэг хувьцааг эзэмшигч оролцсон бөгөөд хурлын ирц 86,1% -тайгаар хурал хүчин төгөлдөр эхэллээ.

Хурлыг тус компанийн ТУЗ-ийн дарга Д.Оюунжаргал нээв.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- Сайн байцгаана уу. “Орхон хөгжил” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцож байгаа та бүхэн энэ өдрийн мэнд хүргэе. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал эхэлж байна. Та бүхэнд хурлын дэг болон хэлэлцэх асуудлуудыг танилцуулъя. Бид энэ удаагийн хурлаар дараах асуудлуудыг авч хэлэлцэнэ. Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. 2026 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж батлах;
3. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах;
4. ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй талаар гаргасан тогтоолыг хэлэлцэх,

Ингээд хурлаар хэлэлцэх эхний асуудал болох “Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан” – г компанийн Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан танилцуулна.

Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан:

Хуралд хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Тус компани анх Орхонтуулын Сангийн аж ахуй нэртэйгээр байгуулагдсан бөгөөд 1991 онд Хөгжил нэртэй 5000 бяруу бордох аж ахуй болж өөрчлөгдөн зохион байгуулагдсан. Засгийн газрын Өмч хувьчлалын комиссын 1991 оны 12-р сарын 02-ны өдрийн 30-р тогтоолоор “Цуу тайж” нэртэйгээр Хувьцаат компани болж, Монголын хөрөнгийн биржид бүртгэгдэн, өмч хувьчлалын ягаан тасалбараар нийт хувьцааны 67 хувийг хувьчилж, 33 хувь нь Төрийн мэдэлд байсан.

МУ-ын Засгийн газрын 1997 оны 160-р тогтоол, ТӨХ-ны 1998 оны 126-р тогтоолоор “Цуу тайж” ХК-ийн төрийн мэдлийн 33 хувь буюу 38'754 ширхэг хувьцааг нээлттэй дуудлага худалдаагаар худалдаж, Төрийн өмчийн хорооны

1998 оны 4-р сарын 17-ний өдрийн 242 тоот тогтоолоор өмчлөх эрхийг 100 % хувьд шилжүүлсэн болно.

Компани нээлттэй зах зээлд 117,437 ширхэг хувьцаа гаргаснаас 101210 ширхэг хувьцаа буюу 86,1 хувийг нэгдмэл сонирхолтой этгээдүүд худалдан авч төвлөрүүлээд байна.

"Орхон хөгжил" ХК нь хувьчлагдсанаас хойш 1991 оноос одоог хүртэл улаан буудайн тариалалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна.

2010 оноос компанийн удирдлага шинэчлэгдсэн бөгөөд компанийн техникийн паркийг шинэчилэх зорилгоор нийт 9 нэр төрлийн 603 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.

Компанийн өнгөрсөн жилийн үйл ажиллагаа

Тайлант 2025 онд тариалангийн ажилд ашиглах техник тоног төхөөрөмжийн засварыг хугацаанд нь хийж гүйцэтгэсэн. Мөн тоног төхөөрөмжөө шинэчлэн хор цацагч, үрлүүр, сийрүүлүүр хийсэн. 2021 онд 1 ширхэг комбайн, трактор худалдаж авсан, 2023 онд техникийн агуулахын барилга, ажилчидын сууц, гал тогооны байр барьсан.

1. Тариалалтын талаар:

Тариалалтыг 5-р сарын 04-ны өдрөөс 5-р сарын 29-ныг дуустал хугацаанд 610 га-д улаан буудай, 604 га-д рапс, 129 га-д арвай нийт 1343 га-д хийж гүйцэтгэв. Тарихын өмнөх боловсруулалтыг трактор, сийрүүлэгчээр гүйцэтгэсэн бөгөөд 130 тн үрийг 8-10 см-ийн гүнд тариалав.

2. Ургац хураалтын талаар;

Комбайны засварын ажлыг хугацаанд нь хийж гүйцэтгэн 4 трактор, 3 комбайныг бэлэн болгож ажиллуулсан. Хураалтын явцад комбайны эвдрэл бага зэрэг гарсан боловч цаг тухайд засварласан.

Тайлант онд 507 га талбайд уринш хийсэн. Уриншийн талбайд гербицид хороор боловсруулалт хийсэн. Хор цацах ажлыг 6-р сарын 15-аас 6-р сарын 25 хүртэл 10 хоног гүйцэтгэв. Уриншийн 2-р үеийн боловсруулалтыг 8-р сарын 8-аас эхэлж сийрүүлэлтийг 10 хоногт хийж гүйцэтгэлээ.

Ургац хураалт өөрийн автомашин техникийг ашиглан 40-45 хоног үргэлжлэв.

3. Үтрэмийн ажлын талаар;

Хураасан будаа болон арвайгаа өөрийн ачигч, цэвэрлэгч, сортлогч машиныг ашиглан стандартад нийцүүлэн "УБ гурил", "Өгөөж гурил" ХХК-д "ХААК" ТӨХК, Дарханы ургамалын газар тариалангийн хүрээлэн-д борлуулсан болно.

2025 онд 830 га-д улаан буудай тариалж 1 га-гаас 11,5 цн буюу нийт 954,5 тн ургац хураасан бөгөөд үүнээс үрэнд 160 тн будаа хадгалж, 758,3 тн улаан буудай борлуулж, 957,1 сая төгрөгний орлого, 70 га-д арвай тариалж 1 га-гаас 10,2 цн буюу нийт 71,4 тн ургац хураан авч борлуулан 84,5 сая төгрөгний орлого олж, үүнээс 773,2 сая төгрөгийн зардал гарсан бөгөөд 343,5 сая төгрөгийн ашигтай ажилласан.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- ТУЗ өмнөх оны ажлыг авч хэлэлцэж 343,5 сая төгрөгийн ашигтай ажилласан гэж дүгнэсэн. Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайханы танилцуулсан тайлангаас тодруулж асуух зүйл байна уу?

Хувьцаа эзэмшигч:

- Асуулт алга.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- Өөр асуух зүйл байна уу? Байхгүй бол дараагийн хэлэлцэх асуудалдаа орёе.

Бидний хэлэлцэх дараагийн асуудлууд болох “Компанийн цаашид хэрэгжүүлэх үйлдвэрлэлийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг батлах”. Энэ асуудлыг та бүхэнд Энэ асуудлыг та бүхэнд ТУЗ – ийн гишүүн Н.Баттогтох танилцуулна.

ТУЗ – ийн гишүүн Н.Баттогтох:

-Хувьцаа эзэмшигч та бүхэн бизнес төлөвлөгөөтэй танилцан шийдвэрлэж өгөхийг хүсье. /Төслийг танилцуулав/

ТУЗ – ийн гишүүн Баянжаргал:

- Компанийн цаашид хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй танилцлаа дэмжиж байна. Асуух зүйл алга

Хурлын дарга Д.Оюунжаргал:

Компанийн бизнес төлөвлөгөөтэй холбогдуулан санал хүсэлт байхгүй бол хурлын дараагийн асуудалд орёе. За дараагийн хэлэлцэх асуудал ТУЗ-ын ногдол ашиг тараахгүй талаар гаргасан тогтоолыг хэлэлцэх, энэ асуудлыг та бүхэнд Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан танилцуулна.

Гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан:

- Орхон хөгжил ХК нь өмнөх онуудад алдагдалтай ажилласан, ХААН банкны зээлтэй, өнгөрсөн жилүүдийн ургац хураалт, тариалалт үйлдвэрлэл болон үйл ажиллагааны зардалд зориулан хувь хүн байгууллагаас тоног төхөөрөмжийн сэлбэг материал, шатах, тослох материал, хор бордоог авахаар зээл авсан байгаа энэ оны орлогоороо банк болон хувь хүн байгууллагаас авсан зээл, зээлийн хүү бусад тоног төхөөрөмжийн төлбөрөө төлж, алдагдалаа нөхөж ажиллаж байгаа тул ногдол ашиг хувиарлахгүй байхаар шийдвэрлэсэн.

ТУЗ-ийн гишүүн Н.Мөнхзул:

- дэмжиж байна. Асууж тодруулах зүйл алга байна.

Хурлын дарга Д.Оюунжаргал:

- За тэгвэл бидний өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудал дуусч байна. Ингээд санал хураалтаа эхлүүлье.

Хувьцаа эзэмшигчээс өөр санал, асуулт гараагүй тул санал хураалтыг эхлэв.

Саналын хуудсыг тооллогын комисст хүлээлгэн өгсний дараа хурлын дарга хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн төслийг танилцууллаа.

Тооллогын комиссын дүнг Тооллогын комиссын дарга Х.Сарнай танилцуулав.

Санал хураалтанд хуралд оролцогчид 100% оролцож нийт саналын хуудас дахь асуулгыг 100% дэмжсэн байна.

“Орхон хөгжил” ХК-ийн 2026 оны 04 сарын 28-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлын дагуу **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар батлав.
2. 2026 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны төлөвлөгөөг оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар батлав.
3. Компанийн цаашид хэрэгжүүлэх үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөг оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар батлав.
4. Компанийн ТУЗ-ийн ногдол ашиг хувиарлахгүй талаар гаргасан тогтоолыг оролцсон гишүүдийн 100%-ийн саналаар батлав.

Хурлын дарга Д.Оюунжаргал хурлыг хаав.

Хурал: 12.00 цагт өндөрлөв.

Хурлын дарга: Д.Оюунжаргал

Тэмдэглэл хөтөлсөн: Г.Урантогос

